



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2026/131/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорнод аймаг

2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нармандах

Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг

Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2025.12.25 № 323

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ш.БАТЖАВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 36.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бүтээгдэхүүний жагсаалтаас өөр нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан авч зарцуулсан.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

2126050098

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын нь 2025 онд 5 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" буюу 81.6 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	576,142,717.07	446,835,904.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	368,797,743.93	245,073,783.45
312	Банканд байгаа бэлэн мөнгө	368,797,743.93	245,073,783.45
31211	Төрийн сангийн харилцах	368,797,743.93	245,073,783.45
35	БАРАА МАТЕРИАЛ	207,344,973.14	201,762,120.89
351	Түүхий эд материал	4,660,700.00	-
35110	Тусгай зориулалттай материал	4,660,700.00	-
354	Хангамжийн материал	202,684,273.14	201,762,120.89
35410	Бичиг хэргийн материал	73,202,917.10	74,330,922.85
35420	Аж ахуйн материал	110,502,076.04	100,571,218.04
35430	Сэлбэг хэрэгсэл	1,390,000.00	1,390,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,589,280.00	25,469,980.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,456,047,913.95	6,407,943,516.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,456,047,913.95	6,407,943,516.60
392	Биет хөрөнгө	6,400,711,643.07	6,354,035,916.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,553,917,354.77	6,611,072,294.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	(701,393,397.73)	(1,033,054,022.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,000,000.00	75,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(75,000,000.00)	(75,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	556,143,534.00	671,549,604.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(250,885,383.79)	(299,554,432.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	166,036,556.12	393,024,133.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(51,262,792.46)	(75,023,586.60)
39209	Зам, гүүрийн байгууламж	18,014,115.16	17,973,089.56
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6,610,255.80)	(9,636,686.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	112,809,349.90	13,401,552.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	(78,434,230.41)	(9,355,989.42)
39217	Ном	22,025,643.31	13,288,808.71
393	Биет бус хөрөнгө	55,336,270.88	53,907,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	55,336,270.88	53,907,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,032,190,631.02	6,854,779,420.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	312,320.00	1,034,993.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	312,320.00	1,034,993.20
413	Өглөг	312,320.00	1,034,993.20
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	312,320.00	159,993.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	875,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,031,878,311.02	6,853,744,427.76
51	Засгийн газрын хувь оролцоо	7,031,878,311.02	6,853,744,427.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	434,020,522.80	434,020,522.80
51101	Өмч: - төрийн	434,020,522.80	434,020,522.80
512	Хуримтлагдсан үр дүн	5,969,965,288.41	5,832,079,162.10
51210	Өмнөх үеийн үр дүн	1,291,878,627.90	6,010,213,045.37
51220	Тайлант үеийн үр дүн	4,678,086,660.51	(178,133,883.27)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	627,892,499.81	587,644,742.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,032,190,631.02	6,854,779,420.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,782,186,805.00	2,598,262,303.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,718,050,805.00	333,390,803.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,718,050,805.00	333,390,803.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,532,800.00	300,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,232,800.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	300,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,705,720,606.40	326,305,103.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,797,398.60	6,785,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,064,136,000.00	2,264,871,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,992,948,000.00	2,154,582,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,992,948,000.00	2,154,582,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,188,000.00	110,289,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,188,000.00	110,289,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,102,777,242.81	2,736,655,773.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,102,777,242.81	2,736,655,773.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,102,773,392.81	2,635,072,272.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,345,235,573.97	1,713,403,702.76
210101	Үндсэн цалин	879,625,208.19	1,061,304,011.53
210102	Нэмэгдэл	416,977,973.11	574,653,799.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	48,889,999.51
210104	Урамшуулал	46,541,823.51	28,555,892.44
210105	Гэрээт ажлын хөлс	2,090,569.16	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,133,187.82	214,136,616.34
210201	Тэтгэврийн даатгал	108,843,928.36	146,322,672.70
210202	Тэтгэмжийн даатгал	23,822,021.41	17,229,370.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,006,795.21	10,070,977.16
210204	Ажилгүйдлийн даатгал	6,010,984.81	8,171,095.99
210205	Эрүүл мэндийн даатгал	23,449,458.03	32,342,500.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,748,000.00	98,127,999.00
210301	Гэрэл, цахилгаан	29,017,164.86	43,726,529.00
210302	Түлш, халаалт	35,930,835.14	54,401,470.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	33,610,281.45	12,603,352.25
210401	Бичиг хэрэг	12,586,350.00	-
210402	Тээвэр, шатахуун	3,042,224.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,896,600.00	-
210408	Бараа материал акталсны зардал	12,085,107.45	12,603,352.25
2105	Нормативт зардал	159,625,208.00	134,775,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	299,600.00	-
210502	Хоол, хүнс	159,325,608.00	134,775,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,436,150.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	5,436,150.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,900,471.16	28,812,557.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,232,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,667,671.16	28,812,557.58
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	288,084,520.41	427,212,144.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,695,804.67	34,005,357.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,559,250.00	7,507,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	249,829,465.74	385,699,787.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,850.00	101,583,501.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	-	97,422,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	97,422,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,850.00	4,161,001.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,850.00	4,161,001.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,679,409,562.19	(138,393,470.36)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,322,901.68	39,740,412.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,322,901.68	35,079,712.92
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал		4,660,700.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,322,901.68)	(39,740,412.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,678,086,660.51	(178,133,883.27)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,071,668,800.00	2,265,171,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,532,800.00	300,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,532,800.00	300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,532,800.00	300,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,232,800.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,064,136,000.00	2,264,871,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,992,948,000.00	2,154,582,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,992,948,000.00	2,154,582,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,188,000.00	110,289,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,188,000.00	110,289,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,866,240,173.62	2,388,895,460.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,866,240,173.62	2,388,895,460.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,803,719,911.62	2,288,456,959.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,344,943,253.97	1,713,556,029.56
210101	Үндсэн цалин	877,395,543.99	1,061,616,331.53
210102	Нэмэгдэл	417,657,938.30	574,493,806.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	48,889,999.51
210104	Урамшуулал	47,799,202.52	28,555,892.44
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	2,090,569.16	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,133,187.82	214,136,616.34
210201	Тэтгэврийн даатгал	116,748,878.62	146,322,672.70
210202	Тэтгэмжийн даатгал	13,383,984.08	17,229,370.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,468,470.58	10,070,977.16
210204	Ажилгүйдлийн даатгал	6,425,267.66	8,171,095.99
210205	Эрүүл мэндийн даатгал	25,106,586.88	32,342,500.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,748,000.00	100,127,999.00
210301	Гэрэл, цахилгаан	29,017,164.86	43,726,529.00
210302	Түлш, халаалт	35,930,835.14	54,401,470.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	88,000,240.00	135,045,900.00
210502	Хоол, хүнс	88,000,240.00	135,045,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,436,150.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	5,436,150.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,472,471.16	28,812,557.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,232,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,239,671.16	28,812,557.58

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,986,608.67	90,777,857.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,993,608.67	80,117,157.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,993,000.00	10,660,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,520,262.00	100,438,501.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,516,412.00	96,277,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,516,412.00	96,277,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,850.00	4,161,001.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,850.00	4,161,001.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	205,428,626.38	(123,723,960.48)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	205,428,626.38	(123,723,960.48)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	163,349,117.55	368,797,743.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	368,797,743.93	245,073,783.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	1,291,878,627.90	2,353,791,650.51
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	1,291,878,627.90	2,353,791,650.51
Тайлант үеийн үр дүн	-	-	4,678,086,660.51	4,678,086,660.51
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	5,969,965,288.41	7,031,878,311.02
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	5,969,965,288.41	7,031,878,311.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	40,247,756.96	40,247,756.96
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	6,010,213,045.37	7,072,126,067.98
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(40,247,756.96)	-	(40,247,756.96)
Тайлант үеийн үр дүн	-	-	(178,133,883.27)	(178,133,883.27)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,020,522.80	587,644,742.86	5,832,079,162.10	6,853,744,427.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,561,354,500.00	2,278,606,460.48	282,748,039.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,561,354,500.00	2,278,606,460.48	282,748,039.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,462,495,600.00	2,182,328,960.48	280,166,639.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,958,148,800.00	1,713,556,029.56	244,592,770.44
210101	Үндсэн цалин	1,220,684,500.00	1,061,616,331.53	159,068,168.47
210102	Нэмэгдэл	707,755,100.00	574,493,806.08	133,261,293.92
210104	Урамшуулал	29,709,200.00	28,555,892.44	1,153,307.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	48,889,999.51	(48,889,999.51)
2102	Ажил олгогчоос нийгмийн	244,768,400.00	214,136,616.34	30,631,783.66

	даатгалд төлөх шимтгэл			
210201	Тэтгэврийн даатгал	166,442,600.00	146,322,672.70	20,119,927.30
210202	Тэтгэмжийн даатгал	19,581,400.00	17,229,370.10	2,352,029.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,790,700.00	10,070,977.16	(280,277.16)
210204	Ажилгүйдлийн даатгал	9,790,700.00	8,171,095.99	1,619,604.01
210205	Эрүүл мэндийн даатгал	39,163,000.00	32,342,500.39	6,820,499.61
2105	Нормативд зардал	135,054,100.00	135,045,900.00	8,200.00
210502	Хоол хүнс	135,054,100.00	135,045,900.00	8,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,558,000.00	28,812,557.58	745,442.42
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	29,558,000.00	28,812,557.58	745,442.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,949,300.00	90,777,587.00	4,171,713.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,288,300.00	80,117,157.00	4,171,143.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,678,000.00	10,660,700.00	17,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,858,900.00	96,277,500.00	2,581,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	98,858,900.00	96,277,500.00	2,581,400.00
213205	Төрөөс олгох тэтгэмж урамшуулал	98,858,900.00	96,277,500.00	2,581,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,204,738,200.00	2,158,315,700.00	46,422,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,204,738,200.00	2,158,315,700.00	46,422,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,204,738,200.00	2,158,315,700.00	46,422,500.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	300,000.00	(300,000.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	368,797,743.93	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	245,073,783.45	-

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	110,289,000.00	110,289,000.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	110,289,000.00	106,127,999.00	4,161,001.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,289,000.00	106,127,999.00	4,161,001.00
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	104,289,000.00	100,127,999.00	4,161,001.00
210301	Гэрэл, цахилгаан	48,289,000.00	43,726,529.00	4,562,471.00
21302	Түлш халаалт	54,000,000.00	54,401,470.00	(401,470.00)
21303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	6,000,000.00	-
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00	-
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,161,001.00	(4,161,001.00)
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,161,001.00	(4,161,001.00)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 36.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 17.6 сая төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

3.1 Албан шаардлага

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бүтээгдэхүүний жагсаалтаас өөр нэр төрлийн 39,697.3 мянган төгрөгийн бүтээгдэхүүн худалдан авч зарцуулсан, үнэлгээний хорооны тэмдэглэл ирүүлээгүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг гишүүн тус бүр баталгаажуулаагүй, хүнсний материал худалдан авах гэрээг байгуулахдаа нийлүүлэх хүнсний барааны жагсаалт, нэгжийн үнийг хавсаргаагүй, тухайн багцын төсөвт өртгийг /гэрээний үнэ/ гэрээнд тусгаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.1-д “Гэрээний үнэ”, 39.3.2-т “Гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл”, 48 дугаар зүйлийн 48.4.6-д “Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл зөвлөмж,” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн ба зохистой байх санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бүтээгдэхүүний жагсаалтаас өөр нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан авч зарцуулсан, үнэлгээний хорооны тэмдэглэл ирүүлээгүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг гишүүн тус бүр баталгаажуулаагүй, хүнсний материал худалдан авах гэрээг байгуулахдаа нийлүүлэх хүнсний барааны	1	36,697.3			1	36,697.3							

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

жагсаалт, нэгжийн үнийг хавсаргаагүй, тухайн багцын төсөвт өртгийг /гэрээний үнэ/ гэрээнд тусгаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй												
Дүн	1	36,697.3			1	36,697.3						